

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



БИЗНЕСИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Чанартай сургалт, судалгаа, үйлчилгээ бүхий хөтөлбөрөөр иргэдийн оюуны чадварыг сайжруулж нийгмийн хөгжлийг урагшлуулна.



Эрхэм оюутнууд аа,
Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.

Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.

Хүн бүрдэд ажил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.

Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.

Б.ЦОГТМБАЯР

Валютын ханш

	АНУ доллар	1,944.78
	Евро	2,205.19
	Японы иен	16.50
	Швейцар франк	2,099.51
	Шведийн крон	234.82
	Английн фунт	2,933.51
	ОХУ-ын рубль	28.17
	БНХАУ-н юань	311.21
	БНСУ-ын вон	1.78
	Канадын доллар	1,537.68
	Малайзын ринггит	535.97
	Туркийн лира	806.96



Зээлжих зэрэглэлийг тогтоодог болно



Монгол Улсын зээлжих зэрэглэлийг өсгөлөө, буурууллаа, Монголын томоохон банкуудын зээлжих зэрэглэл өөрчлөгдлөө гэсэн мэдээллүүд ойр ойрхон цацагддаг. Харин дотооддоо компани, аж ахуйн нэгжийн хувьд зээлжих зэрэглэл тогтоодог байгууллага манай улсын хувьд одоогоор огт байхгүй юм. Зээлжих зэрэглэлийн байгууллага тухайн зээлдэгч нь санхүүгийн үүргээ хугацаандаа барагдуулж чадах эсэх төсөөллийг хөрөнгө

оруулагчдад хамгийн бодитойгоор өгч чаддаг.

Тиймээс Санхүүгийн зохицуулах хорооноос зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхэд анхаарч эхэлжээ. Тус хороо маргааш “Зээлжих болон санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох тогтолцоог Монгол Улсад хөгжүүлэх, түүний ач холбогдол” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах юм байна. Хэлэлцүүлэгт Монголбанк, Сангийн яам зэрэг төрийн байгууллагууд, МҮХАҮТ, Монголын Хөрөнгийн бирж, арилжааны банкууд, үнэт цаас, даатгалын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагууд, аудит, санхүүгийн зах зээл дэх мэргэжлийн холбоод, групп компаниудын удирдлагууд оролцоно. Тэдгээр хүмүүс зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээний ач холбогдол, олон улсын туршлага, Монгол Улсын санхүүгийн зах зээлд хэрхэн нэвтрүүлж, хөгжүүлэх, цаашдын үр бүтээлтэй хамтын ажиллагааны талаар санал солилцох юм.

Дэлдэн чих булан

- Бизнесийн ухааны тэнхимийн Монгол улсын гавъяат эдийн засагч, бизнесийн удирдлагын магистр, профессор багш маань “Татварын хураангуй” номоо хэвлүүлэн гаргаж оюутан, багш нарын гарын авлага болгож сургуульдаа оюуны том хөрөнгө оруулалт хийлээ.
- ACBSP-н тайланг бизнесийн ухааны тэнхимийн багш нар амжилттай бичиж дуусгалаа.
- Үндэсний тэтгэлэгийг зөвхөн 3-аас дээш голчтой оюутнуудад олгох Засгийн газрын шийдвэр гарлаа.



Банкууд зээлийн хүүгээ өсгөх үү?

Яагаад ийн асуух болов гэж гайхах хэрэггүй болов уу. Өнгөрсөн долоо хоногт /1.14-ний өдөр/ Монголбанкны дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж, Мөнгөний бодлогын хүүг нэг нэгжээр нэмэгдүүлэн 13 хувь болгох шийдвэр гаргасан. Үүнээс шалтгаалаад арилжааны банкууд зээлийн хүүгээ өсгөх эсэх нь анхаарал татаж байна. Бодлогын хүү, зээлийн хүү шууд хамааралтай гэсэн зах зээлийн анхдагч ойлголттой хүмүүс цоонгүй бий. Энэ утгаараа арилжааны банкууд зээлийн хүүгээ өсгөх магадлалтай, тэр хэрээр зээл хумигдаж, аж ахуйн нэгжүүд зээлийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа өргөтгөх боломжгүй болох нь гэсэн болгоомжлол нийгэмд бий болжээ. Тиймээс бид "Мөнгөний бодлогын хүүг дагалдаж арилжааны банкуудын зээлийн хүү өсөх үү" гэсэн асуултын хариуг албаны хүмүүсээс авлаа. Хамгийн түрүүн Мөнгөний бодлогын хүүг өсгөх шийдвэр гарсан өдөр Монголбанкны захирал Н.Золжаргал дээрх асуултад хэрхэн хариулсныг харъя. "Зээлийн хүүний тооцоонд ордог гол тооцоолол нь бодлогын хүү мөн. 2012 онд бодлогын хүү 13.25 хувь байхад инфляци 14 хувьтай, зээлийн хүү 18 хувьтай байсан байна. Эндээс бодлогын хүүг нэмэх нь зээлийн хүүнд шууд хамааралтай гэхээс илүү зээлийн эрсдэл нөлөөлдөг гэж хэлж болно. Тэр өнцгөөс харвал эдийн засагт бий болоод буй эрсдэл арилж, валютын орох урсгал нэмэгдвэл заавал зээлийн



хүүг нэмэх шаардлагагүй" гэсэн хариултыг өгсөн байна.

Харин Монголын банкны холбооны шинэхэн Ерөнхийлөгч О.Орхон "Bloomberg TV Mongolia"-д өгсөн ярилцлагадаа "Монголбанкны хувьд зах зээлд үүсээд байгаа нөхцөлтэй уялдуулан бодлогын хүүг өсгөх шийдвэр гаргасан байх. Энэ бол гарах ёстой шийдвэр. Эдийн засаг хэт халалттай байх үед гаргасан шийдвэрийг буцаан залруулж байна гэж ойлгож болно. Бодлогын хүү өснө гэдэг бол зээлийн хүүгийн өртөг өсөхийн дохио л доо. Зээлийн хүү өсөхөөр аж ахуйн нэгжүүд өндөр хүүтэй зээл авч, бизнес эрхлэх сонирхол буурдаг. Нөгөө талаар банкуудад зээл өгөхөөс илүү өөр өндөр өгөөжтэй зүйлд хөрөнгөө байршуулах боломж гардаг. Энэ бүхний нөлөөнд зээл буурна" хэмээн тайлбарлажээ.

Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын орлогч Л.Соронзонболд:

"Арилжааны банк болгоны нөхцөл байдал, боломж харилцан адилгүй. Тиймээс банкууд нөхцөл байдалдаа дүгнэлт хийж байж зээлийн хүүгээ өсгөх эсэхийг

шийдэх учиртай. Бодлогын хүүг дагалдаад зээлийн хүүгээ өсгөлөө гэхэд буруутгах аргагүй. Манай банкны хувьд зээлийн хүүгээ өсгөөгүй, үйл ажиллагаа урьдын адил хэвийн явагдаж байна. Хойшид зээлийн хүүг өсгөх эсэх нь улс орны эдийн засаг, зах зээл ямар байгаагаас шалтгаална гэлээ.

Голомт банкны байгууллагын банкны газрын захирал Л.Оюун-Эрдэнэ:

"Монголбанк Мөнгөний бодлогын хүүгээ нэг нэгжээр нэмэгдүүлсэн нь банкуудын зээлийн хүүд нөлөөлнө. Аажимдаа нөлөөлж, хүү нэмэгдүүлэх магадлалтай. Гэхдээ манай банкны хувьд зээлийн хүүгээ нэмээгүй байгаа гэсэн хариултыг өгч байна.

Өнгөрсөн жилүүдэд банк санхүүгийн зах зээлд зээл их хэмжээгээр нэмэгдсэн гэсэн тооцоо бий. 2012-2013 онд банкуудын зээл 40-50 хувиар өссөн бол өнгөрсөн 2014 онд 16 хувь болтлоо буурчээ. Энэ тоо энэ онд дахин буурах магадлалтайг мэргэжлийнхэн үнүйсгэхгүй байна. Банкны зээл эдийн засгийн өсөлтөд шууд уялдаатай байдаг онцлогтой. Тиймээс зээл буурахын хэрээр эдийн засаг ч мөн хумигдах гаргалгаа харагдаж байгаа юм. Ийм нөхцөлд хувийн секторынхон зээлийн эх үүсвэрээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжгүйг банкны лидэрүүдийн яриа баталж байна.

Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс зөвлөмж гаргалаа

2015 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралдаанаар Монгол Улсын эдийн засгийн 2015 оны төлөв, хандлага, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцээд Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж хүргүүлээ. Тус зөвлөмжийг бүрэн эхээр нь хүргэж байна.

Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж

Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанаар эдийн засгийн 2015 оны төлөв, хандлага, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцлээ. Дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Уул уурхайн салбараас хэт хамаарсан манай эдийн засагт сүүлийн гурван жилийн дотор гадаад валютын орох урсгал ДНБ-ий 72 хувьтай тэнцэх хэмжээгээр дутагдсанаас эдийн засгийн өнөөгийн хүндрэл бий болсон. Тухайлбал, 2011 онтой харьцуулбал 2012-2014 онуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт -6.8 тэрбум, экспортын орлого -2.2 тэрбум ам.доллараар тус тус буурсан байна.

2. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь 2015 онд эдийн засгийг агшуулахгүй байлгах, хувийн хэвшилд ирэх ачаалал, дарамтыг

бууруулах, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн дотоод актив, хуримтлал, хадгаламжийг үнэгүйдлээс сэргийлэх, ажлын байрыг хамгаалах, эдийн засгийг дунд, урт хугацаанд тогтвортой тэлэх нөхцөлийг бүрдүүлэх үндсэн шийдэл хэвээр байсаар байна.

3. Эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн харилцан уялдаа бүхий макро бодлогын цогц өөрчлөлтийг хийх нь төлбөрийн тэнцлийг ашигтай болгох, Монгол Улсын гадаад активыг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийг 2015 онд дахин тогтворжуулахад дэмжлэг үзүүлэхээр байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс Засгийн газарт дараах зөвлөмжийг хүргүүлэхээр тогтлоо. Үүнд:

Макро бодлогын өөрчлөлтийн нэгдсэн төлөвлөгөө (СМАР)-г боловсруулан хэрэгжүүлж, энэ хүрээнд:

Нэгд. Гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх,

Хоёрт. Улсын төсвийн зохистой бодлого хэрэгжүүлэх,

Гуравт. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эрчимжүүлэх арга хэмжээ авах.

Эдгээр арга хэмжээг нэгдсэн байдлаар хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалж, нийгэм-эдийн засагт тогтворгүй байдал үүсэхээс сэргийлэн, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг хангах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалт 74 хувиар буурчээ



Урсгал тэнцэл 985.0 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал нь өнгөрсөн оны мөн үеэс 69%-иар буурсан. Үүнд барааны гадаад худалдааны дансны алдагдал 176%-иар буюу 2,322.7 сая ам.доллараар буурч 1,002.0 сая ам.долларын ашигтай гарсан нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгө, санхүүгийн тэнцэл 813.1 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 43%-иар буюу 625.0 сая ам.доллараар буурсан үзүүлэлт бөгөөд энэ нь Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт 74%-иар буюу 1,556.3 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.

Багцын хөрөнгө оруулалтын данс ашигтай гарахад Самурай бондийн эх үүсвэр нөлөөлсөн бол бусад хөрөнгө оруулалтын алдагдал буурахад Хятадын Ардын банкттай хийсэн своп хэлцэл, Хөгжлийн банкны гадаадаас авсан зээлийн эх үүсвэр болон аж ахуйн нэгж байгууллагуудын гадаад худалдааны авлагын дүн голлох нөлөөг үзүүлжээ.